

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Жаргалант сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2025/003/НА-СТА-ОНТС

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2025 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Ахлах аудитор: О.Гантуяа
Утас: 70350757 Цахим хаяг: gantuyao@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.02.25 № 63
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Л.УЧРАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Жаргалант сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/521 дүгээр тушаалаар "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-д өөрчлөлт оруулснаар 2024 онд зөвхөн хоршоонд зээл олгох болсон байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд 1 удаа төсөл сонгон шалгаруулалт зарлаж, төсөл сонгон шалгаруулалтаар 1 хоршоонд 100,000.0 мянган төгрөгийн зээл олгосон байна.

Бусад асуудал

Хоршоо хөгжүүлэх сангийн 2024 оны гүйцэтгэлийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>272,088,388.22</u>	<u>279,557,588.22</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	<u>132,821,488.22</u>	<u>85,427,339.22</u>
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	132,821,488.22	85,427,339.22
3122	Гадаад валют	132,821,488.22	85,427,339.22
31221	Төрийн сангийн харилцах	132,821,488.22	85,427,339.22
33	АВЛАГА	<u>139,266,900.00</u>	<u>194,130,249.00</u>
335	Бусад авлага	139,266,900.00	194,130,249.00
3351	Байгууллагаас авах авлага	139,266,900.00	194,130,249.00
	Хувь хүмүүсээс авах авлага		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>272,088,388.22</u>	<u>279,557,588.22</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>231,800,000.00</u>	<u>231,800,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	231,800,000.00	231,800,000.00
413	Өглөг	231,800,000.00	231,800,000.00
4136	Бусад өглөг	231,800,000.00	231,800,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	231,800,000.00	231,800,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>40,288,388.22</u>	<u>47,757,588.22</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	40,288,388.22	47,757,588.22
512	Хуримтлагдсан үр дүн	40,288,388.22	47,757,588.22
51210	Өмнөх үеийн үр дүн	35,333,619.00	40,288,388.22
51220	Тайлант үеийн үр дүн	4,954,769.22	7,469,200.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>272,088,388.22</u>	<u>279,557,588.22</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>81,132,288.22</u>	<u>53,344,051.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	81,132,288.22	53,344,051.00
120	Нийтлэг татварын бус орлого	81,132,288.22	53,344,051.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	81,132,288.22	45,874,851.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,954,769.22	7,171,236.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		298,964.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	<u>400,000.00</u>	<u>738,200.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>400,000.00</u>	<u>738,200.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	400,000.00	738,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	400,000.00	-
210401	Бичиг хэрэг	100,000.00	-
210402	Тээвэр шатахуун	300,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	<u>738,200.00</u>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	738,200.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>4,954,769.22</u>	<u>7,469,200.00</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>4,954,769.22</u>	<u>7,469,200.00</u>

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	52,537,549.65	43,527,168.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	52,537,549.65	43,527,168.55
120	Нийтлэг татварын бус орлого	52,537,549.65	43,527,168.55
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	52,537,549.65	43,527,168.55
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,681,085.59	21,179,896.48
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,856,464.06	22,347,272.07
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,762,000.00	5,722,775.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,762,000.00	5,722,775.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,762,000.00	5,722,775.00
2104	Хангамж, бараа материалын зардал	900,000.00	1,599,000.00
210401	Бичиг хэрэг	300,000.00	400,000.00
210402	Тээвэр шатахуун	600,000.00	700,000.00
210408	Бараа материал акталсны зардал		499,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,862,000.00	4,123,775.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,862,000.00	4,123,775.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	49,775,549.65	37,804,393.55
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	49,775,549.65	37,804,393.55

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	52,537,549.65	53,344,051.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	52,537,549.65	53,344,051.00
120	Нийтлэг татварын бус орлого	81,132,288.22	53,344,051.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	81,132,288.22	45,874,851.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	81,132,288.22	7,170,236.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		298,964.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (2)	2,762,000.00	738,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,762,000.00	738,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,762,000.00	738,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	900,000.00	0.00
210401	Бичиг хэрэг	300,000.00	0.00
210402	Тээвэр шатахуун	600,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,862,000.00	738,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,862,000.00	738,200.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	49,925,549.65	100,738,200.00
14	Бусад эх үүсвэр	367,374.322.17	0.00
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	367,374.322.17	100,738,200.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	400,000,000.00	100,738,200.00
230001	Эргэж төлөгдөх зээл	400,000,000.00	100,738,200.00

7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(32,625,677.83)	-100,738,200.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	17,299,871.82	47,394,149.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	229,916,698.54	132,821,488.22
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	247,216,570.36	85,427,339.22

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	35,333,619.00	35,333,619.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	35,333,619.00	35,333,619.00
C07	Тайлант үеийн үр дүн			4,954,769.22	4,954,769.22
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	40,288,388.22	40,288,388.22
D01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	0.00	0.00	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	40,288,388.22	40,288,388.22
D08	Тайлант үеийн үр дүн			7,469,200.00	7,469,200.00
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	47,757,588.22	47,757,588.22

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	227,820,200.00	100,738,200.00	127,082,000.00	37.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,000,000.00	738,200.00	261,800.00	73.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,000,000.00	738,200.00	261,800.00	73.82
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	738,200.00	261,800.00	73.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	738,200.00	261,800.00	73.82
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	226,820,200.00	100,000,000.00	250,000,000.00	44.08
230001	Эргэж төлөгдөх зээл	226,820,200.00	100,000,000.00	126,820,200.00	44.08
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	186,165,539.22	-	-
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	186,165,539.22	-	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	45,874,851.00	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	7,469,200.00	-	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	132,821,488.22	-	-

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	132,821,488.22	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	85,427,339.22	-	--

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 46,613.0 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 46,613.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- Үр дүнгийн тайланд үндсэн зээлийн орлого 45,874.8 мянган төгрөг, 738.2 мянган төгрөгийн зардлаа тусгаагүй зөвхөн хүүгийн орлого 7,469.2 мянган төгрөгийг тайлагнасан нь УСНББОУС 1, 2 болон аудитын иж бүрэн байх, оршин байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй тул санхүүгийн тайланг залруулав.

Аудитаар нийт 2,487.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 2,487.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Аудитаар залруулаагүй зөрчилтэй асуудлаас 2,487.0 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь тогтоосон материаллаг байдлын дүнгээс бага байгаа тул өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн болно.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сангаас 2013-2017 онд олгосон зээлээс 2 зээлдэгч зээлийн гэрээний үүргийн биелэлтийг хангуулаагүй, үндсэн зээлийн төлбөрийн 2,487.0 төгрөгийн төлөлт хийгээгүй хугацаа хэтэрсэн байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 10.1-д "Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина", 10.4-т "Зээлдэгч нь зээлийг гэрээнд заасан хугацааны дотор эргэн төлөх үүргээ биелүүлээгүй тохиолдолд жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь чанаргүй активын ангилалд оруулж, Монгол банкны зээлийн мэдээллийн санд чанаргүй зээлдэгчийн ангилалд бүртгэнэ", 10.5-д "Зээлдэгчийн гэрээнд эрсдэл үүссэн тохиолдолд зээлийн хөрөнгийг эргүүлэн татах ажиллагааг сумын Засаг дарга болон хяналтын зөвлөл хариуцан зохион байгуулна. Энэхүү зохицуулалтыг зээлийн гэрээгээр нарийвчлан зохицуулна", 11.1-д "Сангаас зээл авсан этгээд зээлийг үр ашиггүй зарцуулсан буюу зориулалтын дагуу зарцуулаагүй, зээлийн болон барьцааны гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайн этгээдэд олгосон хөнгөлөлттэй зээлийг буцаан төвлөрүүлэх бөгөөд сангаас дахин зээл олгохгүй" гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж 1:

Зээл төлөлтийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу хянаж, эрсдэл үүссэн тохиолдолд журмын дагуу арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн тайланд үндсэн зээлийн орлого 45,874.8 мянган төгрөг, 738.2 мянган төгрөгийн зардлаа тусгаагүй зөвхөн хүүгийн орлого 7,469.2 мянган төгрөгийг тайлагнасан байна.	1	46,613.0	1	46,613.0			1	46,613.0				
Дүн	1	46,613.0	1	46,613.0			1	46,613.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сангаас 2013-2017 онд олгосон зээлээс 2 зээлдэгч зээлийн гэрээний үүргийн биелэлтийг хангуулаагүй, үндсэн зээлийн төлбөрийн 2,487.0 төгрөгийн төлөлт хийгээгүй хугацаа хэтэрсэн байна.	1	2,487.0					1	2,487.0				
Дүн	1	2,487.0					1	2,487.0				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс таггалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ОНТС	1	1			1			
	НИЙТ	1	1			1			